

ХАСБАНКНЫ ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХАРААТ БУС ГИШҮҮНИЙ ТАЙЛАН

Эми Чой

2024 оны 2 дугаар улирал



МЭДЭГДЭЛ

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”)-ийн Хараат бус гишүүн **Эми Чой** миний бие: (i) Компанийн тухай хууль (“КтХ”), Банкны тухай хууль (“БтХ”); (ii) Монголбанкны холбогдох журмууд болох “Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам” (“Засаглалын хяналт шалгалтын журам”), “Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам” (“Хараат бус гишүүний журам”); (iii) ХасБанкны Дүрэм болон бусад холбогдох засаглалын бодлого, зарчмын дагуу энэхүү Хараат бус гишүүний тайлан (“Тайлан”)-г бэлтгэсэн болно.

Тайлан нь дараах хугацааг хамарна: 2024 оны 2 дугаар улирал (“Тайлант хугацаа”).

1.ОРОЛЦООНЫ ТАЙЛАГНАЛ

(Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.1 болон 5.2.2 дахь заалт)

Тайлант хугацаанд Хүснэгт 1-т заасан дараах хурлуудад оролцож ажиллалаа.

Тайлант хугацаан дахь ТУЗ болон ТУЗ-ийн дэргэдэх Хороодын хурлууд

Хүснэгт 1

Хурлууд	Оролцсон байдал	Огноо
ТУЗ-ийн хурал	Хараат бус гишүүнээр	2024 оны 4 дүгээр сарын 09-15 2024 оны 4 дүгээр сарын 29 2024 оны 5 дугаар сарын 02 2024 оны 5 дугаар сарын 21-27 2024 оны 5 дугаар сарын 24-29 2024 оны 5 дугаар сарын 27-31 2024 оны 6 дугаар сарын 17-21 2024 оны 6 дугаар сарын 21-27
Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал	Хараат бус гишүүнээр	2024 оны 4 дүгээр сарын 29
ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны хурал (“АХ”)	Хорооны даргаар	2024 оны 4 дүгээр сарын 29 2024 оны 5 дугаар сарын 02
ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны хурал (“ЭУХ”), цахим санал хураалт	Хорооны гишүүнээр	2024 оны 4 дүгээр сарын 09-15 2024 оны 4 дүгээр сарын 29 2024 оны 5 дугаар сарын 02 2024 оны 5 дугаар сарын 21-27 2024 оны 5 дугаар сарын 27-31 2024 оны 6 дугаар сарын 21-27
ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшуулын хорооны хурал (“ЗНДЦУХ”)	Хорооны гишүүнээр	2024 оны 4 дүгээр сарын 29 2024 оны 5 дугаар сарын 02 2024 оны 6 дугаар сарын 17-21

1.1 ТУЗ-ИЙН ХУРЛУУД

1.1.1 ТУЗ-ийн ээлжит хурал 2024 оны 5 дугаар сарын 02-ны өдөр дараах асуудлуудыг хэлэлцэж, хуралдав. Үүнд:

- 1 ТУЗ-ийн өмнөх шийдвэр, зөвлөмжийн талаарх явцын мэдээлэл;
- 2 ТУЗ-ийн дэргэдэх Хороодын тайлан: ТУЗ-ийн гишүүдийн гэрээний загвар
 - 2.1 ЗНДЦУХ
 - 2.2 АХ
 - 2.3 ЭУХ
- 3 Удирдлагын тайлан: (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар);
- 4 ХасБанкны жижиг хөрөнгө оруулагчдад зориулсан хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрх хэрэгжүүлэх журам (хуулийн заалтын дагуу Бодлого батлах шаардлагатай);
- 5 ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанкинд нэгтгэх ажиллагааны хүрээнд авч хэрэгжүүлэх дараагийн алхмуудын явцын мэдээлэл;
- 6 Стратегийн сэдэв: шимтгэлийн орлого болон харилцах, хадгаламжийг нэмэгдүүлэх;
- 7 Мэдээлэл технологи, цахим шилжилтийн явцын мэдээлэл;
- 8 Бусад.

Хэлэлцсэн асуудал #2.1 ТУЗ-ийн гишүүдийн гэрээний загвар, мөн #4 ХасБанкны жижиг хөрөнгө оруулагчдад зориулсан хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрх хэрэгжүүлэх журам: Хурлын дээрх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

Хэлэлцсэн асуудал #6 Стратегийн сэдэв: Шимтгэлийн орлого болон харилцах, хадгаламжийг нэмэгдүүлэх:

_____ гэдгийг би тэмдэглэв. _____
 _____ миний зүгээс санал болгосон.

1.1.2 ТУЗ-ийн ээлжит бус хурал

- Төлөөлөн удирдах зөвлөлийн ээлжит бус хурал 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хуралдаж, хурлаар дараах асуудлыг хэлэлцэв:
 1. ТУЗ-ийн дэргэдэх байнгын хороодын бүрэлдэхүүнийг батлах.

Хэлэлцсэн асуудал #1: Хурлын дээрх шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

- Хүснэгт 2-т заасан дараах ТУЗ-ийн цахим санал хураалтын хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ТУЗ-ийн цахим санал хураалтын хурлууд

Хүснэгт 2

Хурал	Санал хураалт	Огноо
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Банкны 2024 оны тогтворжуулах төлөвлөгөөг батлах тухай	2024 оны 4 дүгээр сарын 09-15
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Банкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээл (кредит картын хугацааг сунгах), ("Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл")	2024 оны 5 дугаар сарын 21-27



ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Амины орон сууц худалдан авах зээл, ("Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл")	2024 оны 5 дугаар сарын 24-29
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. [REDACTED]-ийн зээлийн багцын хугацааг сунгах, зээлийн шугамын хязгаарыг нэмэгдүүлэх хэлцэл ("Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл")	2024 оны 5 дугаар сарын 27-31
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. ТУЗ-ийн Үнэлгээний үр дүнгийн тухай 2. ТУЗ-ийн үнэлгээний журам (2019)-ын шинэчилсэн найруулгыг батлах тухай 3. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай 4. ТУЗ-ийн сургалтын хөтөлбөрийг батлах тухай 5. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журмыг батлах тухай	2024 оны 6 дугаар сарын 17-21
ТУЗ-ийн цахим санал хураалтын хурал	1. Банкны 3-н холбогдох этгээдийн кредит картын хугацааг сунгах хэлцэл ("Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл")	2024 оны 6 дугаар сарын 21-27

Миний зүгээс цахим санал хураалтын хурлын дээрх бүх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.2 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ АУДИТЫН ХОРООНЫ ХУРАЛ ("АХ")

Хүснэгт 3-т заасан дараах АХ-ны хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь АХ-ны хурлууд

Хүснэгт3

Огноо	Хэлэлцсэн асуудал
2024 оны 4 дүгээр сарын 29	1. АХ-ны даргыг сонгох .
2024 оны 5 дугаар сарын 2	1. Аудитын тайлан: 1.1 Аудитын явцын тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар); 1.2 2024 оны аудитын спринт тайлан- цикл 2; 2. Банкны холбогдох этгээдүүдийн улирлын тайлан (МонголБанкны журам).

Миний зүгээс 4 дүгээр сарын 29-ны өдөр АХ-ны даргаар Б.Уламбаярыг сонгох шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй. Намайг АХ-ны зүгээс холбогдох тогтоолд төлөөлөн гарын үсэг зурахаар томилсон.

Хэлэлцсэн асуудал #1.1 Аудитын явцын тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар): Хэлэлцсэн асуудал #1.1 Аудитын явцын тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар): Алдаануудыг эрт



илрүүлэх, алдааны тохиолдлыг бууруулах дохио өгөх механизмын шинэ процесс нэвтрүүлсэнд багт баяр хүргэв. Илрүүлсэн алдааны тоо мөн өгч буй дохиог харуулсан шинэ процессийн ач холбогдлын талаарх товч танилцуулга нэмэхийг санал болгосон.

Хэлэлцсэн асуудал #1.2 2024 оны аудитын спринт тайлан- цикл 2: [redacted]
[redacted]
[redacted] талаар асуусан. Гүйцэтгэх захирал [redacted]
[redacted] гэв.

1.3 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЭУХ”)

Хүснэгт 4-т заасан дараах ЭУХ-ны хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ЭУХ-ны хурлууд		Хүснэгт4
Огноо	Хэлэлцсэн асуудал	
2024 оны 4 дүгээр сарын 9-15 өдрийн цахим санал хураалтын хурал	1. Банкны 2024 оны тогтворжуулах төлөвлөгөөг батлах тухай	
2024 оны 4 дүгээр сарын 29	1. ЭУХ-ны даргыг сонгох.	
2024 оны 5 дугаар сарын 2	1. ХасБанкны эрсдэлийн тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар); 2. Хянан нийцүүлэлтийн явцын мэдээ/тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар); 3. [redacted]; 4. 2024 оны 1 дүгээр улиралд хийсэн холбогдох этгээд/сонирхлын зөрчилтэй хэлцэл.	
2024 оны 5 дугаар сарын 21-27 өдрийн цахим санал хураалтын хурал	1. Банкны эрх бүхий албан тушаалтанд олгох зээл (кредит картын хугацааг сунгах), (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)	
2024 оны 5 дугаар сарын 24-29 өдрийн цахим санал хураалтын хурал	1. Амины орон сууц худалдан авах зээл, (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)	
2024 оны 5 дугаар сарын 27-31 өдрийн цахим санал хураалтын хурал	1. [redacted]-ийн зээлийн багцын хугацааг сунгах, зээлийн шугамын хязгаарыг нэмэгдүүлэх хэлцэл (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)	
2024 оны 6 дугаар сарын 21-27	1. Банкны 3-н холбогдох этгээдийн кредит картын хугацааг сунгах хэлцэл (“Холбогдох этгээдийн бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл”)	

Миний зүгээс ЭУХ-ны дээрх санал хураалтын бүх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.



ЭУХ-ны даргаар Албертус Браггинкийг сонгох шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

2024 оны 5 дугаар сарын 2-ны өдрийн хурлаар хэлэлцсэн асуудал #2: Хянан нийцүүлэлтийн явцын мэдээ/тайлан (2024 оны 1 дүгээр улирлын байдлаар): [redacted] харилцагчаа таньж мэдсэн байдлын талаар асуув. Эрсдэл хариуцсан захирал хариулахдаа, Банк нь харилцагчаа таньж мэдэх маш хатуу бодлого баримталдаг бөгөөд бүх тохиолдлыг ямар ч хөнгөлөлт, чөлөөлөлтгүйгээр хянаж үздэг гэв.

1.4 ТУЗ-ИЙН ДЭРГЭДЭХ ЗАСАГЛАЛ, НЭР ДЭВШҮҮЛЭХ, ЦАЛИН УРАМШУУЛЫН ХОРООНЫ ХУРАЛ (“ЗНДЦУХ”)

Хүснэгт 5-т заасан дараах ЗНДЦУХ-ны хуралд оролцсон.

Тайлант хугацаан дахь ЗНДЦУХ-ны хурлууд		Хүснэгт 5
Огноо	Хэлэлцсэн асуудал	
2024 оны 4 дүгээр сарын 29	1. ЗНДЦУХ-ны даргыг сонгох.	
2024 оны 5 дугаар сарын 2	1. ТУЗ-ийн гишүүний гэрээний загварыг шинэчлэн батлах.	
2024 оны 6 дугаар сарын 17-21	1. ТУЗ-ийн Үнэлгээний үр дүнгийн тухай; 2. ТУЗ-ийн үнэлгээний журам (2019)-ын шинэчилсэн найруулгыг батлах тухай; 3. ТУЗ-ийн 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах тухай; 4. ТУЗ-ийн сургалтын хөтөлбөрийг батлах тухай; 5. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журмыг батлах тухай.	

Миний зүгээс ЗНДЦУХ-ны дээрх санал хураалтын бүх шийдвэрүүдийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

ЗНДЦУХ-ны даргаар Майкл Мадденийг сонгох шийдвэрийг дэмжсэн бөгөөд зөрүүтэй байр суурь байгаагүй.

1.5 ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРАЛ (ХЭЭХ) 2024 ОНЫ 4 ДҮГЭЭР САРЫН 29

Хүснэгт 6-д заасан ХХЭХ-д оролцсон.

Хавсралт6		
№	Хэлэлцсэн асуудал	Шийдвэр
1.	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын ирцийн танилцуулга	Хурлын ирц хүчин төгөлдөр бүрдсэн.
2.	ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлангийн танилцуулга	Танилцуулгыг Гүйцэтгэх захирал хийв. Энэ нь батлах асуудал биш болно.

3.	ХасБанкны 2023 оны аудитлагдсан санхүүгийн тайлангийн танилцуулга	Танилцуулгыг Санхүү хариуцсан захирал хийв. Энэ нь батлах асуудал биш болно.
4.	ХасБанкны 2023 оны үйл ажиллагааны тайлан болон аудитлагдсан санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн дүгнэлтийг батлах	Дүгнэлтийг Хурлын дарга танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
5.	ХасБанкны ТУЗ-ийн Хараат бус гишүүдийн тайлан	Тайланг Хувьцаа эзэмшигчдэд танилцуулав. Энэ нь батлах асуудал биш болно.
6.	ХасБанкны 2023 оны жилийн эцсийн цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах эсэх тухай шийдвэр	Асуудлыг Гүйцэтгэх захирал танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
7.	Ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх бүрэн эрхэд холбогдуулан ХасБанкны Дүрэм болон Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах эсэх тухай шийдвэр	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулав. - ХасБанк ХК-ийн Дүрэмд өөрчлөлт оруулах тухай асуудлаар хуралд оролцсон саналын эрхтэй нийт хувьцаа эзэмшигчдийн 98.94 хувь нь татгалзсан санал өгсөн тул батлагдаагүй болно. - Ногдол ашгийн бодлогод өөрчлөлт оруулах тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
8.	Фреймворк гэрээ байгуулах эсэх шийдвэр	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
9.	Бодлогын гэрээ байгуулах эсэх шийдвэр	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
10.	ХасБанкийг нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулах эсэх шийдвэр	Асуудлыг Гүйцэтгэх захирал танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.

11.	Хувьцаа эзэмшигчдийн 2026 оны ээлжит хурал хүртэл хугацаанд бүрэн эрх хэрэгжүүлэх ТУЗ-ийн гишүүдийн сонгон шалгаруулалт	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулав. Нэр дэвшигч бүр дээр кумулятив аргаар санал хураалтыг явуулж, ТУЗ-ийн гишүүдийг сонгох/дахин сонгов.
12.	ТУЗ-ийн гишүүний цалин урамшууллыг шинэчлэн тогтоох эсэх тухай шийдвэр	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.
13.	ТУЗ-ийн 2024 оны төсвийг батлах	Асуудлыг Хууль хариуцсан захирал, ТУЗ-ийн НБД танилцуулж холбогдох тогтоолыг хувьцаа эзэмшигчид батлав.

Миний бие Улаанбаатар хот, Шангри Ла зочид буудлын Их танхимд зохион байгуулсан ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд биечлэн оролцсон болно. Тус хурал нь банк хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараах анхдугаар хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал байв. Хэлэлцэх асуудалтай холбоотой тогтоолын төслүүдийг танилцуулж, хувьцаа эзэмшигчид баталсан.

Хэлэлцсэн асуудал #5 ТУЗ-ийн Хараат бус гишүүдийн тайлан: Уг тайланг Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд танилцуулахаас өмнө бүх гурван хараат бус гишүүн хянасан болно.

2. СОНИРХЛЫН ЗӨРЧИЛТЭЙ ХЭЛЦЭЛ БА ИХ ХЭМЖЭЭНИЙ ХЭЛЦЛИЙН ТАЙЛАН

(БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг болон Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.3 дахь заалт)

БтХ-ийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэгт Банкны ТУЗ-ийн Хараат бус гишүүн нь сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө гэж заасан.

Тайлант хугацаанд, ТУЗ хэд хэдэн сонирхлын зөрчилтэй хэлцэл баталсан: ТУЗ-ийн хурлаар 2024 оны 5 дугаар сарын 27-ны өдөр 1 (нэг), 2024 оны 5 дугаар сарын 29-ны өдөр 1 (нэг), 2024 оны 5 дугаар сарын 31-ний өдөр 1 (нэг), 2024 оны 6 дугаар сарын 27-ны өдөр 3 (гурв). Миний бие эдгээр бүх хэлцэлд оролцож, саналаа өгч ажилласан.

ТУЗ-ийн гишүүдээс сонирхлын зөрчилтэй гишүүн байсан тохиолдолд тухайн гишүүн нь хурлын эхэнд ашиг сонирхлын зөрчилтэй гэдгээ мэдэгдэж, хэлэлцсэн асуудалд санал өгөөгүй болохыг тэмдэглэж байна.

3. ЗАСАГЛАЛЫН ТАЙЛАН

(КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэг, Хараат бус гишүүний журмын 5 дугаар зүйлийн 5.2.4 дахь заалт болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3 дугаар зүйлийн 3.5 дахь хэсэг)

Дээр дурдсан хууль тогтоомжоор Хараат бус гишүүн нь Банкны оролцогч талууд, түүний дотор Хувьцаа эзэмшигч, харилцагч, хадгаламж эзэмшигч болон банкны ажилтны эрх ашгийг хамгаалах үүднээс ТУЗ, Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаа, гаргасан бодлого, шийдвэр нь Банкны эрх ашиг, сонирхолд нийцсэн эсэх, мөн үйл ажиллагаа нь хууль тогтоомж дүрэм журамд нийцсэн эсэхэд хяналт тавих эрхтэй.

Банкны засаглалыг дүгнэхэд:

КтХ-ийн 79 дүгээр зүйлийн 79.3 дахь хэсэгт заасан арга хэмжээ	
КтХ 79.3.1 болон Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.5 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХУУЛЬ ТОГТООМЖ, ДҮРЭМ, ЖУРМЫН НИЙЦЭЛ)	ТУЗ болон удирдлагын баг хууль тогтоомжийг дагаж мөрдөхийн тулд бүх хүчин чармайлтаа гаргаж, нарийн зүйлүүдийг анхаарч авч үздэгийг ажигласан. Жишээ дурдвал; Удаан үргэлжилсэн олон нийтэд хувьцаагаа санал болгосны дараах ТСН-ийг ХасБанкинд нэгтгэх асуудлыг хувьцаа эзэмшигчид 2024 оны 4 дүгээр сарын 29-ний ХЭЭХ-аар эцэслэн баталсан.
КтХ 79.3.2 (БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ИЛ ТОД БАЙДАЛ)	ТУЗ болон удирдлагын баг үүргээ хангалттай хэмжээнд ил тод гүйцэтгэж байгааг би ажигласан. Анхаарал татахуйц ямар нэгэн асуудал ажиглагдаагүй.
КтХ 79.3.3 (ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙГ МЭДЭЭЛЛЭЭР ХАНГАХ)	Хувьцаагаа олон нийтэд санал болгосоны дараах анхдугаар Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2024 оны 4 дүгээр сарын 29-ний өдөр хуралдсан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.1 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА, ГАРГАСАН ШИЙДВЭР НЬ БАНКНЫ ЭРХ АШИГТ НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын багийн гаргасан шийдвэр нь банкны эрх ашигт нийцэж байгааг ажигласан.

Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.2 (ТУЗ, ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА НЬ ХУУЛЬ ТОГТООМЖИД НИЙЦСЭН ЭСЭХ)	ТУЗ болон удирдлагын баг бүх цаг үед холбогдох хууль тогтоомжид нийцүүлж, хичээн ажиллаж байсныг ажигласан.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.3 (БАНКНЫ ХАРИЛЦАГЧ, ХАДГАЛАМЖ ЭЗЭМШИГЧДИЙН ЭРХ АШГИЙГ ХАМГААЛАХ)	ТУЗ болон удирдлагын багийн зүгээс банкны харилцагч, хадгаламж эзэмшигчдийн ашиг сонирхолд сөргөөр нөлөөлсөн аливаа үйлдэл, шийдвэр гаргаагүй.
Засаглалын хяналт шалгалтын журмын 3.5.6 (МОНГОЛБАНКИНД ЗӨРЧИЛ МЭДЭЭЛЭХ)	Мэдээлэх ямар ч асуудал ажиглагдаагүй болно.

4. БУСАД

2024 оны 4 дүгээр сарын 30-ны өдөр Банкны Дархан хот дахь харилцагч болон салбараар зочлов.

- ТУЗ-ийн гурван гишүүн (Хувьцаа эзэмшигчдийн нэр дэвшүүлсэн 2 гишүүн болон миний бие) Дархан хот дахь 3 салбар нэгж, 5 харилцагч, 1 захын үйл ажиллагаатай танилцахаар Дархан хотыг зорив.
- Салбарын хамт олон сэтгэл хангалуун, банкны үйл ажиллагаанд үнэнч, удирдлагын түвшинд тогтвортой ажиллаж байгаа нь өмнөх Улаанбаатар дахь салбаруудад зочилсонтой ижил төстэй ажиглалт байв.

- [Redacted text block]
- [Redacted text block]

Огноо: 2024 оны 6 дугаар сарын 28

Гарын үсэг: Эми Чой